Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдийн хорт зуршлын хэрэглээг судалсан дүн

Ц.Отгонзаяа[1], Д.Оюунчимэг[1], Д.Хишигтогтох[2]

[1]Этүгэн их сургууль
[2]АШУҮИС, НЭМС

Түлхүүр үг:
Халдварт бус өвчин
Эрсдэлт хүчин зүйлс
Архи
Тамхины хэрэглээ

Товч утга: Үндэслэл: Тархвар зүйн шилжилтийн улмаас сүүлийн 20-иод жилд дэлхийн хүн амын өвчлөл, нас баралтын шалтгааны бүтцэд өөрчлөлт орж, зан үйлийн сөрөг дадалтай хамаарал бүхий цусны эргэлтийн тогтолцооны өвчин, хавдар, осол гэмтлийн өвчлөл, нас баралт нэмэгдэн, эдийн засагт учруулах дарамт нэмэгдэж байгаа нь нийгмийн эрүүл мэндийн тулгамдсан асуудал болж байна. **Зорилго:** Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдийн хорт зуршлын (архи, тамхи) хэрэглээг судлах. **Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй:** Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар, өрхийн эрүүл мэндийн төвд суурилж 2019 оны 7-11 сард явуулсан. Судалгаанд Ховд аймгийн Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй 165 насанд хүрсэн хүн хамрагдсан. Судалгааны мэдээ материалыг Монгол улсад хийгдсэн халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох Steps 2013 судалгааны стандарт асуумжийг ашиглан, биоанагаахын ёс зүйн зөвшөөрлийн (дугаар №2) дагуу цуглуулсан. **Үр дүн:** Нийт судалгаанд хамрагдсан хүмүүсийн 44.2% (n=73) нь эрэгтэй, 55.8% (n=92) нь эмэгтэй хүмүүс байв.

ӨГҮҮЛЭЛ

Үндэслэл: ДЭМБ-ын мэдээгээр Халдварт бус өвчин дэлхийн хүн амын 43 хувь, нас баралтын шалтгааны 60 хувийг эзлэж байгаа бөгөөд 2020 он гэхэд өвчлөлийн 60 хувь, нас баралтын 73 хувьд хүрэх магадлалтайг урьдчилан тооцоолоод байна.[1,4] Монгол улсад хийгдсэн халдварт бус өвчин (ХБӨ)-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох STEPS 2013 оны судалгаанаас үзэхэд: Судалгааны хүн амын дунд тамхи таталтын тархалт 27.1 хувь байсан ба нийт эрэгтэйчүүдийн 49.1 хувь, эмэгтэйчүүдийн 5.3 хувь нь тамхи татдаг байна. Насны бүлгээр авч үзвэл, нийт тамхи татдаг тэр дундаа эрэгтэйчүүдийн дотор 15-24 насныхан бусад бүлэгтэй харьцуулахад бараг хоёр дахин их байна. Нийт хүн амын дунд архины хэрэглээ өндөр бөгөөд архи, согтууруулах ундаа хэрэглэгчдийн 28.2 хувь (95% ИХ 16.1-23.5) нь сүүлийн 12 сард, харин 36.3 хувь (95% ИХ 34.6-42.7) нь сүүлийн 30 хоногт ямар нэг хэмжээгээр архи, согтууруулах ундаа хэрэглэсэн байна. Сүүлийн 12 сард архи хэрэглэсэн үзүүлэлт хүйс болон бүс нутагт статистик ач холбогдол бүхий ялгаагүй байгаа нь хэрэглээг анхаарах шаардлагатайг харуулж байна.[2,3] ХБӨ-ний эрсдэлт хүчин зүйлс, өвчлөлийн тархалтын талаар орон нутагт хийсэн судалгаа харьцангуй хомс байгаа нь цаашид урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, нотолгоонд суурилсан мэдээлэлд үндэслэн, бүс нутгийн онцлогт суурилж үйл ажиллагааг төлөвлөх, шийдвэр гаргах суурь мэдээлэл бүрдүүлэх нь бидний судалгааны ажлын үндэслэл боллоо.

Зорилго: Өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлэгчдийн хорт зуршлын (архи, тамхи) хэрэглээг судлах.


Судалгааны хэрэглэгдэхүүн ба арга зүй: Судалгааг аналитик судалгааны агшингийн загвараар, өрхийн эрүүл мэндийн төвд суурилж 2019 оны 7-11 сард явуулсан. Судалгаанд Ховд аймгийн Баатархайрхан өрхийн эрүүл мэндийн төвөөр үйлчлүүлж буй 165 насанд хүрсэн хүн хамрагдсан. Судалгааны мэдээ материалыг Монгол улсад хийгдсэн халдварт бус өвчний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох Steps 2013 судалгааны стандарт асуумжийг ашиглан, биоанагаахын ёс зүйн зөвшөөрлийн (дугаар №2) дагуу цуглуулсан.

Үр дүн:

Хүснэгт 1. Сүүлийн 12 сар архи, согтууруулах ундааг хэрэглэсэн тоо (насны бүлэг, хүйсээр)

Үзүүлэлт	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт хүн ам	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Насны ангилал						
>19	2	1	0	0	2	0.5
20-24	5	0.7	2	0.2	7	0.45
25-29	6	0.4	8	0.5	14	0.45
30-34	11	0.5	10	0.4	21	0.45
35-39	3	0.4	4	0.5	7	0.45
40-44	3	0.4	4	0.5	7	0.45
45-49	5	0.4	6	0.5	11	0.45
50-54	4	0.5	4	0.5	8	0.5
55-59	8	0.8	1	0.1	9	0.45
60-64	3	1	0	0	3	0.5
65-69	1	1	0	0	1	0.5
70<	1	1	0	0	1	0.5
Бүгд	52	0.6	39	0.2	91	0.4

Хүснэгт 1-ээс харахад судалгаанд 91 хүн хамрагдсанаас 25-29, 30-34 насны хүмүүсийн хэрэглээний тоо 38.5%(n=35) өндөр, 60 дээш насныханд архины хэрэглээний тоо 5.5%(n=5) бага байна



Зураг 1. Архи, согтууруулах ундааны хэрэглээний давтамж, хүйсээр

Зураг 1-ээс харахад эрэгтэй, эмэгтэйчүүдийн архи согтууруулах ундааны хэрэглээний давтамж улирал, жилд 1-2 удаа хэрэглэдэг тоо өндөр байна.

Хүснэгт 2. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундааг хэрэглэсэн дундаж тоо (насны бүлэг, хүйс)

Үзүүлэлт	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт хүн ам	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Насны ангилал						
>19	0	0	0	0	0	0
20-24	4	1.5	0	0	4	0.7
25-29	2	1.5	6	1.5	8	1.5
30-34	8	2	8	1.7	16	1.8
35-39	2	1.5	2	1	4	1.2
40-44	2	2	2	1	4	1.5
45-49	0	0	3	1	3	0.5
50-54	2	2	1	3	3	2.5
55-59	7	2.2	0	0	7	1.1
60-64	3	1.3	0	0	3	0.6
65-69	1	1	0	0	1	0.5
70<	0	0	0	0	0	0
Бүгд	31	1.2	22	0.7	53	0.9

Хүснэгт 2-оос харахад сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн 53 хүн судалгаанд хамрагдсанаас насны бүлгээр харьцуулан үзэхэд статистик ач холбогдол бүхий ялгаа ажиглагдаагүй байна.

Хүснэгт 3. Сүүлийн 1 сард нэг удаад хамгийн ихээр хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уултын дундаж тоо (насны бүлэг, хүйсээр)

Үзүүлэлт	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт хүн ам	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Насны ангилал						
>19	0	0	0	0	0	0
20-24	4	9	0	0	4	4,5
25-29	2	7.5	6	6.5	8	7
30-34	8	20.3	8	9.7	16	15
35-39	2	20	2	2.5	4	11.2
40-44	2	21.5	2	6	4	13.7
45-49	0	0	3	5.3	3	2.6
50-54	2	14	1	4	3	9
55-59	7	14.8	0	0	7	7.4
60-64	3	10	0	0	3	5
65-69	1	6	0	0	1	3
70<	0	0	0	0	0	0
Бүгд	31	10.2	22	2.8	53	6.5

Хүснэгт 3-аас харахад сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн эрэгтэйчүүдийн нэг удаад хамгийн ихээр хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уултын хэмжээг насны бүлгээр харьцуулан үзвэл 30-34, 35-39, 40-44 насны эрэгтэйчүүдэд хамгийн их буюу стандарт уултаас 3-4 их байна . Харин эмэгтэйчүүдийн нэг удаад хамгийн ихээр хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уултын дундаж хэмжээ 25-29, 30-34 насанд харьцангуй өндөр буюу стандарт уултаас 2 дахин их байна.

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн 30.3 хувь нь тамхи татдаг. Үүнээс 94.0% (n=47) нь эрэгтэй, 6.0% (n=3) нь эмэгтэй хүмүүс тамхи татаж байна.

Хүснэгт 4. Тамхи хэрэглэдэг хүн ам (насны бүлэг ба хүйсээр)


Үзүүлэлт	Эрэгтэй		Эмэгтэй		Нийт хүн ам	
	Тоо	Дундаж	Тоо	Дундаж	Тоо	Дундаж
Насны ангилал						
>19	1	2.0	0	0	1	2.0
20-24	4	8.0	0	0	4	8.0
25-29	5	10.0	0	0	5	10.0
30-34	8	16.0	1	2.0	9	18.0
35-39	2	4.0	0	0	2	4.0
40-44	4	8.0	0	0	4	8.0
45-49	5	10.0	0	0	5	10.0
50-54	5	10.0	0	0	5	10.0
55-59	7	14.0	1	2.0	8	16.0
60-64	3	6.0	1	2.0	4	8.0
65-69	1	2.0	0	0	1	2.0
70<	2	4.0	0	0	2	4.0
Бүгд	47	94.0	3	6.0	50	100.0

Хүснэгт 4-өөс харахад нийт эрэгтэйчүүдийн 94%(n=47), эмэгтэйчүүдийн 6%(n=3) тамхи хэрэглэж байна. Насны бүлгээр авч үзвэл тамхи татдаг эрэгтэйчүүдийн дотор 30-34, 55-59 насны 31.9%(n=15) тамхины хэрэглээ өндөр байна.



Зураг 2. Тамхины хэрэглээг төрөл, хувиар

Судалгаанд 50 хүн хамрагдсанаар 86%(n=44) дийлэнх нь үйлдвэрийн тамхи татаж байна.



Зураг 3. Өдөрт татдаг янжуур тамхины тоо

Судалгаанд хамрагдсан хүмүүсийн тамхи 5-аас бага татдаг хүмүүс цөөн байна. Ихэнхдээ 6-20 хооронд татаж байна.

Хэлцэмж: Халдварт бус өвчний 2009 оны судалгааны үр дүн нь сүүлийн 12 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн хүн амын эзлэх хувь буурсан ч архи хэрэлдэг хүмүүсийн давтамж буурахгүй байна.[2,5] Rebecca P Gelber8 J.Michael Gaziano нарын судалгаагаар архины хэтрүүлэх хэрэглээ эрэгтэйчүүдэд 38.2 хувь, эмэгтэйчүүдэд 8.5 хувь байлаа. Бидний судалгаагаар эрэгтэйчүүдийн дунд архины хэрэглээ өндөр байна.[7]

Судлаач С.Цэгмэд нарын (2002) УБ хотод хөдөлмөрийн насныхны дунд хийсэн судалгааны дүнтэй харьцуулахад эрэгтэйчүүдийн 56.3 хувь, эмэгтэйчүдийн 17 хувь нь тамхи татдаг манай судалгааны эрэгтэйчүүдийн 94 хувь, эмэгтэйчүүдийн 6 хувь байгаа нь бидний судалгааны үр дүнтэй ойролцоо байлаа.[8] Хятадад эрэгтэйчүүдийн 60.8 хувь, эмэгтэйчүүдийн 4.2 хувь, БНСУ-д эрэгтэйчүүдийн 53.8 хувь, эмэгтэйчүүдийн 5.6 хувь тамхи татаж байгаа нь манай судалгаанд хамрагдсан эрэгтэйчүүдээс харцангуй бага харин эмэгтэйчүүдийн эзлэх хувь ойролцоо байна.[9]

Дүгнэлт: Судалгаанд хамрагдсан хүн амын 25-34 насны хүмүүсийн дунд архи согтууруулах ундааны хэрэглээ өндөр байна. Судалгааны хамрагдсан эрэгтэй, эмэгтэйчүүдийн дийлэнх нь улирал, жилд 1-2 удаа архи, согтууруулах ундааны хэрэглээ өндөр байна. Сүүлийн 1 сард архи, согтууруулах ундаа хэрэглэсэн тоог статистик ач холбогдол бүхий ялгаагүй байна. Харин нэг удаад хамгийн ихээр хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уултын хэмжээ 30-44 насны эрэгтэйчүүдэд хамгийн их буюу 21.5 стандарт байна. Эмэгтэйчүүдэд нэг удаад хамгийн ихээр хэрэглэсэн архи, согтууруулах ундааны стандарт уултын дундаж хэмжээ 25-34 насанд 9.7 стандарт байна.
Нийт эрэгтэйчүүдийн 94.0 хувь, эмэгтэйчүүдийн 6.0 хувь нь одоогийн байдлаар тамхи хэрэглэж байна. Тамхи татдаг эрэгтэйчүүдийн 30-34, 55-59 насныхны дунд бусад насны бүлэгтэй харьцуулахад тамхины хэрэглээ өндөр байна. Дунджаар 13 ширхэг тамхи татаж байна.

Ном зүй:

1. *Preventing noncommunicable disease by reducing environmental risk factors, WHO 2017*
2. *Монгол улсад хийгдсэн халдварт бус өвчин (ХБӨ)-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох STEPS 2009 судалгааны тайлан*
3. *Монгол улсад хийгдсэн халдварт бус өвчин (ХБӨ)-ний эрсдэлт хүчин зүйлсийн тархалтын түвшинг тогтоох STEPS 2013 судалгааны тайлан*
4. *Эрүүл мэндийн үзүүлэлт, 2018*
5. *WHO methods and data sources for global burden of disease estimates 2000-2015*
6. *REPORT OF THE 2010 GLOBAL SURVEY*
7. *Rebecca P Gelber8 J.Michael Gaziano, JoAnn E Manson. A prospecitive study of body mass index and risk of developing hypertension in men. Am J Hypertens. 2007 April; 20(4): 370-377*
8. *С.Цэгмэд. Улаанбаатар хотод хөдөлмөрийн насны хүмүүсийн дундах зарим эрсдэлт хүчин зүйлсийн судалгаа. Улаанбаатар 2002.*
9. *WPRO TFI Fact Sheet, http://www.wpro.who.int/sites/tfi/fact_sheets/,*

Substance abuse prevalence among patients in a family medical center

Ts. Otgonzaya[1], D. Oyunchimeg[1], D. Khishigtogtokh[2]

[1]Etugen university
[2]MNUMS, School of public health

Introduction: Morbidity and mortality structure significantly changed, especially habit or life-style related disorders, such as cardio-vascular disorders, cancer and accidental injury and mortality is increasing, and disease related economic load is becoming a challenging issue. Public health is confronting this problem.
Purpose: To evaluate for substance abuse prevalence in family center patients.
Materials and methods: Analytic cross-sectional study design was used and study period was from July to November of 2019. 165 adults participated in this study who is referred to family medical center of "Baatar Khairkhan" of "Khovd" province. Standard questionnaire of STEPS 2013 was used for data collection and biomedical ethical approval was approved (number 2).
Results: 44.2% (n=73) of patients were male, 55.8% (n=92) were female. According to the groups 25-29- and 30-34-year-old group substance usage was high and low in the > 60-year-old group.
Usage intervals such as once a year or 1-2 times per season are high in both sexes. There were no differences in a recent month usage for groups. According to the standard drink numbers, 21.5 standard drinks reported in 30-44 age group of male and 9.7 standard drink reported in 25-34 age group of females. Relatively low numbers reported in other age groups. 30.3% of participants were smokers. Among them 94.0% (n=47) are male and 6.0% (n=3) are female.
Smoking rate is higher in groups of 30-34 and 55-59 age groups compared with other age groups.
Most of them smoke factory cigarettes and average cigarette number was 6-20. Smoking less than 5 cigarette rates was low.

Keywords: non-infectious disorders, risk factors, alcohol and tobacco abuse